

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин, аялал жуучлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/161/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.04 № 78

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд шинээр тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих зөвшөөрлийн дуудлага худалдааг зохион байгуулж нэмэлтээр 46,975.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн хөрөнгөөр 17,485.3 мянган төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 188,226.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, 11,085.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 2 хөтөлбөр, 4 зорилт, 105 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 99 арга хэмжээг бүрэн, 3 арга хэмжээг 90.0 хувь, 3 арга хэмжээг 90.0 хувь буюу нийт дүнгээр 98.2 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0702900215

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	113,323.27	414,771.67
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	671,293.96	744,344.78
Нийт хөрөнгийн дүн	784,617.24	1,159,116.45
Нийт өр төлбөрийн дүн	72.00	37,613.51
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	784,545.24	1,121,502.94
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	784,617.24	1,159,116.45
Үйл ажиллагааны орлогын дүн	979,284.41	1,682,993.17
Үйл ажиллагааны зардлын дүн	740,511.97	1,346,035.46
Үйл ажиллагааны үр дүн	238,772.44	336,957.71
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	238,772.44	336,957.71
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	545,768.79	784,545.24
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4.00	-
Тайлант оны үр дүн	238,772.44	336,957.71
Эцсийн үлдэгдэл	784,545.24	1,121,502.94
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	685,797.73	1,310,105.84
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	672,897.93	1,292,620.49
Үйл ажиллагааны ЦМГ	12,899.80	17,485.35
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(12,899.80)	(17,485.35)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	665,156.20	1,172,286.19
Урсгал зардал	665,156.20	1,172,286.19
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	665,156.20	1,172,286.19
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	664,654.70	1,172,236.19
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	501.50	50.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 6,000.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 6,539.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,539.7 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрч 642.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5,897.3 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 241.2 мянган төгрөгийг илүү, ажилласан хоногийг буруу тооцоолон 401.2 мянган төгрөгийг дутуу цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Тухайн цалин, нэмэгдэл тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэмж тусгана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын амралтын цалинтай давхардуулан олгосон цалинг төлүүлж орон нутгийн орлого болгох, дутуу олгосон цалин ажилчдад олгох төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр байгууллагын даргын шийдвэрээр төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 2-т "Салбарын онцлог, гүйцэтгэлд суурилсан үр дүнг харгалзан үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг цалингийн доод хэмжээнээс нэмэгдүүлэх асуудлыг тухайн жилийн батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй", Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 2-т "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ерөнхийлөн захирагч нарт даалгасугай" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэн шийдвэрийг холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Байгууллагын нягтлан бодогчид ажлын байрны тодорхойлолтод заасан ажлаар хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин 1,197.3 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно."Ажлын байрны тодорхойлолт"-д заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын цалин хөлсийг олгох албан шаардлага хүргүүлсэн.

3. Шатахуун зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд бөөн дүнгээр тайлагнаж хөтөлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг хууль журмын дагуу хөтөлж байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Зах зээлийн үнээс өндөр үнэтэй 4,700.0 мянган төгрөгийн анонс бэлтгэсэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж		
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	6,000.0	-	-	1.00	6,000.00	1	6,000.0	-	-	-	-	
Дүн		1	6,000.0	0	-	1	6,000.0	1	6,000.0	0	-	-	-	

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 241.2 мянган төгрөгийг илүү, ажилласан хоногийг буруу тооцоолон 401.2 мянган төгрөгийг дутуу цалин олгосон	1	642.4	1	642.4	-	-	-	-	-	-
	Байгууллагын нягтлан бодогчид ажлын байрны тодорхойлолтод заасан ажлаар хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин 1,197.3 мянган төгрөгийг олгосон	1	1,197.3	-	-	1	1,197.30	-	-	-	-

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр байгууллагын даргын шийдвэрээр төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин нэмэгдүүлсэн.	1	-	-	1	-	-	-	-
	Шатахуун зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд бөөн дүнгээр тайлагнаж хөтөлсөн.	1	-	-	1	-	-	-	-
	Зах зээлийн үнээс өндөр үнэтэй 4,700.0 мянган төгрөгийн анонс бэлтгэсэн.	1	4,700.0	-	1	-	4,700.0	-	-
Нийт		5	6,539.7	1	4	642.4	5,897.3	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Байгаль орчин, аялал уучлалын газар	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчиж 22,000.0 мянган төгрөгийн өвсийг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд авалт хийсэн. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 159,546.8 мянган төгрөгийн 5, зарлагын 5,250.0 төгрөгийн 1 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 8,766.5 мянган төгрөгийн 8 шийдвэрийг тус тус мэдээлээгүй.	1	22,000.0	-	-	1	22,000.0	-	-
Дүн		2	22,000.0	-	-	1	22,000.0	1	-